



2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ОНЦЛОХ ҮР ДҮН

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

АУДИТЫН ДҮГНЭЛТ: ӨӨРЧЛӨЛТГҮЙ

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан гэж үзэн өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

ГОЛ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НИЙТ ХӨРӨНГӨ

154.1

тэрбум төгрөг

135.1 → 154.1

↑ **+14.1%**



ӨР ТӨЛБӨР

48.5

тэрбум төгрөг

36.2 → 48.5

↑ **+33.8%**



ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ

105.6

тэрбум төгрөг

98.9 → 105.6

↑ **+6.8%**



МӨНГӨН ХӨРӨНГӨ

30.1

тэрбум төгрөг

31.5 → 30.1

↓ **-4.5%**



ОНХС-ИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ

13.0

тэрбум төгрөг

өмнөх оноос

**+6.2 тэрбум,
1.9 дахин өссөн**

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

НИЙТ ОРЛОГО
БА ТУСЛАМЖ



Төлөвлөгөө 88.7

Гүйцэтгэл 86.5

Гүйцэтгэлийн хувь

97.5%

НИЙТ ЗАРЛАГА
БА ЦЭВЭР ЗЭЭЛ




Төлөвлөгөө 120.3

Гүйцэтгэл 94.3

Гүйцэтгэлийн хувь

78.4%

ЗАРЛАГЫН БҮТЭЦ



Урсгал 68.7%

Хөрөнгө оруулалт 30.6%

Цэвэр зээл 0.7%

ГОЛ АНХААРАХ АСУУДАЛ

- ОНХС-ийн үлдэгдэл өссөн нь төсөл хэрэгжилтийн саатлыг илтгэнэ.
- Төсөвт тодотгол, орлогын тасалдал нь хөрөнгийн зардлын хэрэгжилтэд нөлөөлсөн.
- Хөгжлийн арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан.



2025 ОНЫ АУДИТЫН ДҮГНЭЛТ, ҮР ДҮН

2/4

АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОЙМ,
АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

1. АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОЙМ



1.1 ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Дүгнэлт: **3**
• Өөрчлөлтгүй: **3**
Түүвэр: **64**



1.2 ТТЗ, ТЕЗ, НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Дүгнэлт:
• Өөрчлөлтгүй: **4**
• Хязгаарлалттай: **10**



1.3 ТБОНӨААТҮГ

Дүгнэлт: **6**
• Өөрчлөлтгүй: **6**
Түүвэр: **14**

2. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ



Нийт зөрчил
168



Аудитын шийдвэрийн
нийт мөнгөн дүн
5,792.3
сая төгрөг



Гол анхаарал
татсан асуудал
ОНХС-ийн үлдэгдэл
13.0 тэрбум төгрөгт хүрч,
өмнөх оноос 1.9 дахин өссөн

3. АУДИТЫН ШИЙДВЭРИЙН НЭГТГЭЛ



Төлбөрийн акт
39
229.7
сая төгрөг



Албан шаардлага
89
1,950.3
сая төгрөг



Зөвлөмж
39
3,555.8
сая төгрөг



Хариуцлага
тооцуулах шийдвэр
1
56.8
сая төгрөг



Шилжүүлсэн
асуудал
-
хамаарахгүй

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОССОЙ ЗӨРЧИЛ



Нийт зөрчил:
54.7
сая төгрөг



Төлбөрийн акт:
12 / 32.2
сая төгрөг



Албан шаардлага:
6 / 22.5
сая төгрөг



Зөвлөмж:
1

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧИЛ

Давтамжтай зөрчил, төсвийн гүйцэтгэлийн
аудитын онцлох дүгнэлт

1. ДАВТАМЖТАЙ ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

1



Нэмэгдэл, урамшууллыг
илүү болон давхардуулан
олгосон.

2



Төсвийн хөрөнгийг
зориулалт бусаар
зарцуулсан, хувийн
дансаар хүлээн авсан.

3



Анхан шатны баримт,
НӨАТ-ын баримтыг
хуурамчаар үйлдэж,
хамаарал бүхий этгээдийн
дансаар шилжүүлэг хийсэн.

4



Худалдан авах
ажиллагааг хуульд
нийцүүлэн зохион
байгуулаагүй, тендерийн
журмыг зөрчсөн.

5



ОНХС-ийн санхүүжилтэд
гүйцэтгэлийн, чанарын
болон банкны баталгаагүйгээр
урьдчилгаа олгосон.

6



Хандиваар авсан болон
ашиглаж буй хөрөнгийг
бүртгэлд тусгаагүй.

7



Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг
зориулалтын бусаар ашиглаж,
эрх бүхий этгээдээр гэрээ
байгуулаагүй, сонирхлын
зөрчилтэй хэлцэл хийсэн.

2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ОНЦЛОХ ДҮГНЭЛТ

- 1 Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг 13.1 тэрбум төгрөгөөр буюу 58.3%-иар буурсан.
- 2 ОНХНС-ээс олгох шилжүүлэг 6.9 тэрбум төгрөгөөр буюу 25.8%-иар буурсан.
- 3 Орон нутгийн төсвийг 17.6 тэрбум төгрөгөөр бууруулан тодотгосон.
- 4 376 төсөл, арга хэмжээг 52,974.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэл 56.7% байсан.
- 5 Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 75.5% байсан.
- 6 Авто замын сангийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 84.3% байсан.
- 7 Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тайланг 96.2%-ийн саналаар "Хангалттай" гэж үнэлсэн.

ЗАРЛАГЫН БҮТЭЦ



| | |
|------------------|---------|
| Урсгал | — 68.7% |
| Хөрөнгө оруулалт | — 30.6% |
| Цэвэр зээл | — 0.7% |



ЦААШИД АНХААРАХ ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖ

АУДИТЫН МӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1

ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОДИТОЙ БОЛГОХ



Эх үүсвэр, гэрээ, зах зээлийн нөхцөл, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан орлогын төлөвлөлт хийх.

2

ОНХС БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ



Төсөл, арга хэмжээний зураг төсөв, худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилт, комиссын баримтыг бүрэн хангах.

3

САНХҮҮГИЙН САХИЛГА, ДОТООД ХЯНАЛТЫГ ЧАНГАТГАХ



Давтан илэрч буй зөрчилд хариуцлага тооцож, дотоод аудитыг эрсдэлтэй асуудалд чиглүүлэх.

4

АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТОГТМОЛ ХЯНАХ



Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг сар, улирлаар тайлагнан хянах.

ТУСГАЙ АНХААРАХ АСУУДАЛ

- ОНХС-ийн үлдэгдэл өндөр байгаа нь хэрэгжилтийн саатлыг илтгэнэ.
- Хөрөнгө, авлага, өр төлбөрийн бүртгэлийн чанарыг сайжруулах шаардлагатай.
- Үр ашиггүй зарцуулалт, давтан зөрчилд удирдлагын хариуцлага чухал.
- Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан өөрчлөлтгүй дүгнэлттэй гарсан тул энэ түвшнийг хадгалах дотоод хяналтыг бэхжүүлэх шаардлагатай.

ЗОРИЛТОТ ҮР ДҮН

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бодит нөхөн төлүүлэлт, залруулга, дахин давтагдахгүй дотоод хяналтын сайжруулалтаар баталгаажуулах.